



**ХЭНТИЙ АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 5/05

Чингис хот

Х.Төртогтохыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дүгээр зүйлийн 33.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Тус газрын дэргэдэх Залуучуудын хөгжлийн төвийн нарийн бичгээр Хатантөмөрийн Төртогтохыг 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс томилон ажиллуулсугай.

Хоёр. Х.Төртогтохын албан тушаалын сарын цалинг ТҮ-5-1 шатлалаар тогтоож, олгохыг нягтлан бодогч Д.Ганзулд зөвшөөрсүгэй.

Гурав. Х.Төртогтоход ажил хүлээлгэн өгөх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга
Гишүүд

А.Алтаншагай /Мэргэжилтэн/
Т.Мөнх-Эрдэнэ /Нярав-жолооч/
Т.Наранханд /Бичиг хэрэг, дотоод ажил
хариуцсан ажилтан/

Дөрөв. Батлагдсан ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргээ биелүүлж, төрийн албан хаагчийн ёс зүй, хүүхэд хамгааллын ёс зүйг чанд мөрдөн, идэвх зүтгэл гарган ажиллахыг Х.Төртогтоход даалгасугай.

ДАРГА



Б.ЭНХ-ЭРДЭНЭ

00000 049